



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот


Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд  
оруулсан өөрчлөлтийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгалын зуучлагч “Чанд финтех” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг хавсралтын дагуу бүртгэсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Чанд финтех” ХХК /Ц.Төрболд/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН





Санхүүгийн зохицуулах хорооны  
2020 оны 02 сарын 21 өдрийн  
95-р тогтоолын хавсралт

“ЧАНД ФИНТЕХ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

/төгрөгөөр/

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 10,000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 10,000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	Я.Цэрэнханд / /ХВ59030166/	10,000	100,000,000.00	100%	(10,000)		100,000,000.00			
2	Ц.Төрболд /УЕ82121776/				10,000	100,000,000.00		10,000	100,000,000.00	100%
	<b>Нийт</b>	<b>10,000</b>	<b>100,000,000.00</b>	<b>100%</b>		<b>100,000,000.00</b>	<b>100,000,000.00</b>	<b>10,000</b>	<b>100,000,000.00</b>	<b>100%</b>